



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

“Шинэ их тэрбум аудит” ХХК-ийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Шинэ их тэрбум аудит” ХХК-ийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2.Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Шинэ их тэрбум аудит” ХХК (Д.Дашдулам)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН